

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2016 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/110 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

НИЙСЛЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Мэдээллийн технологийн газар (цаашид “Газар” гэх) нь Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, төрөөс харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах, нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2.Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

1.3.Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 4.2-т заасан төрийн албанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.4.Газар үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж, тайлагнана.

1.5.Газар зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сан банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

2.1.Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.2.Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга, орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга тус тус томилж чөлөөлнө.

2.3.Газар үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга батална.

2.4.Газрын дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

2.5.Газрын дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.1.батлагдсан бүтэц, орон тоо болон хуулиар тогтоосон эрх, хэмжээний хүрээнд ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

2.5.2.холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

2.5.3.хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх;

2.5.4.орлогч дарга, хэлтсийн дарга, албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.5.5.байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.5.6.газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох саналаа Нийслэлийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.5.7.сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

2.5.8.ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;

2.5.9.Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.5.10.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

2.6.Газрын дарга, албан хаагчид Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай Нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана.

2.7.Газрын дарга хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллана.

Гурав. Газрын үндсэн чиг үүрэг

3.1.Газар нь төрөөс харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.харилцаа холбоо, мэдээллийн технологийг хөгжүүлэх талаар төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, хамтарч ажиллах;

3.1.2.нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулахад санал өгөх, тэдгээрийн мэдлэг, ур чадварын түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулах;

3.1.3.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлагад нийцсэн, салбарын сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашигласан, эдийн засгийн хэмнэлтийг бий болгож, үр өгөөжийг нэмэгдүүлэх төслүүдийг санаачлах, хэрэгжүүлэх;

3.1.4.Нийслэлийн Засаг даргын мэдээллийн технологийн талаар баримтлах бодлого, чиглэлийн дагуу салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлттэй уялдуулан мэдээллийн технологийн төслүүдийг төлөвлөх, тооцоо судалгаа хийж, техникийн даалгавар боловсруулах, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.5.батлагдсан төслүүдийг мэргэжлийн байгууллагуудаар зохих журмын дагуу гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, техникийн даалгаврын дагуу чанартай гүйцэтгэхэд нь байнгын хяналт тавих, гүйцэтгэлийг үнэлж шалгах, хүлээн авах, хүлээлгэн өгөх;

3.1.6.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагууд, иргэд, олон нийтэд төслийн үр өгөөжийг таниулан сурталчлах;

3.1.7.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудад программ хангамж, системүүдийг ашиглахтай холбоотой сургалтыг бие даан, эсхүл холбогдох газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах, гарын авлагаар хангах;

3.1.8.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудад хэрэглэх техник, тоног төхөөрөмжийн босго үзүүлэлтийг жил бүр гаргах;

3.1.9.нийслэлийн хэмжээнд мэдээлэл технологийн чиглэлээр хэрэгжүүлэх ажилд нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын мэдээлэл технологийн мэргэжилтэн, албан хаагчдыг удирдан зохион байгуулж, манлайлан оролцох;

3.1.10.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын мэдээлэл технологийн чиглэлээр шинээр нэвтрүүлж байгаа хяналтын камер, шилэн кабел, гадаад, дотоод сүлжээ, сервер, систем болон тоног төхөөрөмжийн техникийн даалгавар боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, санал тусгах, хэрэгжилт болон хүлээлцэхэд хяналт тавих, хууль, эрх зүйн хүрээнд дүрэм, журмыг мөрдүүлж ажиллах;

3.1.11.мэдээллийн системийг эрх зүйн хүрээнд ажиллуулахад шаардлагатай баримт бичгийг боловсруулах, газар, хэлтсүүдээс захиалсан программ хангамжтай холбоотой журам, заавар, аргачлалын талаар санал өгөх.

3.2.Газар нь мэдээллийн технологийн хатуу дэд бүтцийн чиглэлээр дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1.Нийслэлийн нэгдсэн сүлжээ /нэгдсэн төв шугам болон төв шугамаас дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, хороод хүртэлх шилэн кабел/-ний хэвийн, найдвартай ажиллагаа, ашиглалт, засвар үйлчилгээг хариуцаж, хамгаалалтыг сайжруулах, шинэлэг техник, технологи нэвтрүүлэх, байгууллагуудыг шилэн кабелтай холбох ажлыг зохион байгуулах;

3.2.2.нийслэлийн төсвөөр хийсэн болон хийх бүх шилэн кабелийн сүлжээний ашиглалт, үйлчилгээг чиг үүргийн дагуу бүрэн хариуцаж ажиллах;

3.2.3.нийслэлийн Дата төвийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн найдвартай ажиллагаа, өрөөний аюулгүй байдлыг хангах, хүчин чадлыг сайжруулах арга хэмжээ авч, шаардлагатай урсгал засваруудыг хийх;

3.2.4.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг нийслэлийн Дата төвд бий болгож, өгөгдөл солилцох дэд бүтцийг хөгжүүлэх;

3.2.5.байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник, программ хангамжийн хэрэгцээг хөгжлийн түвшинтэй харьцуулан тодорхойлж, шаардлагатай программ, техник, тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.6.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын сервер систем, дотоод сүлжээ, холбоо дохиолол, тоног төхөөрөмж болон интернэт үйлчилгээтэй холбогдон гарсан эвдрэл, гэмтлийг шуурхай засварлах ажлыг зохион байгуулах;

3.2.7.нэгдсэн сүлжээ болон нийслэлийн Дата төвийн цаашдын хөгжил, бодлого чиглэлийг тодорхойлж, техник технологи, программ хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.2.8.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын компьютер, дотуур холбоо, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

3.3.Газар нь мэдээллийн технологийн зөөлөн дэд бүтцийн чиглэлээр дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын www.citycouncil.mn, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын www.ulaanbaatar.mn сайтуудыг цахим халдлагаас хамгаалах, программ техник хангамж, системийн хэвийн ажиллагаа, хөгжүүлэлтийг хариуцан ажиллах;

3.3.2.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын www.ulaanbaatar.mn сайтын мэдээ, мэдээллийн шинэчлэлтийг хариуцаж ажиллах;

3.3.3.нийслэлийн хэмжээнд хариуцсан программ хангамж, системийн ашиглалтыг үр дүнг сайжруулах орчныг бүрдүүлэх, системийн хөгжүүлэлт, найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллах;

3.3.4.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудаас үзүүлдэг үйлчилгээг ил тод, нээлттэй болгон төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний нэгдсэн платформыг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

3.3.5."Аз жаргалтай хот" зорилтын хүрээнд технологийн цогц шийдэл, үйл ажиллагааны инновацийг нэвтрүүлэх;

3.3.6.Улаанбаатар хотын аюулгүй байдлыг хангах, осол, гэмт хэргийн илрүүлэлтийн сайжруулах, замын хөдөлгөөний удирдлагыг дэвшилтэт технологийн тусламжтайгаар оновчтой, үр ашигтай болгох төслийг хэрэгжүүлэх;

3.3.7.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын цахим систем, үйлчилгээнүүдэд тоон гарын үсэг нэвтрүүлэх, дэлгэрүүлэх, ашиглах, тоон гарын үсгийн ашиг тусыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

3.3.8.нийслэлийн нэгдсэн сүлжээнд тулгуурлан нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн программ хангамж, системийн оновчтой шийдлүүдийг нэвтрүүлэх, түгээх;

3.3.9.нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийг хортой кодоос хамгаалах, халдлага илрүүлэх, хариу үйлдэл хийх, системийг сэргээх арга хэмжээ авах;

3.3.10.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын мэдээллийн их өгөгдөл үүсгэх, боломжит өгөгдлүүдийг иргэд, олон нийтэд нээлттэй болгох, их өгөгдлийг ашиглан дүн шинжилгээ хийх, их ба нээлттэй өгөгдлийг инноваци бүтээх, бүтээмжээ нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх гол талбар болгох талаар арга хэмжээ авч ажиллах;

3.3.11.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудаас нэвтрүүлсэн мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, технологийн өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр хийж гүйцэтгүүлэх;

3.3.12.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын интернэт, гадаад, дотоод сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах, шинэлэг

систем, программ /аппликэшн/ нэвтрүүлэх, домэйн хостинг болон сервер, сторэйжээр хангах ажлыг холбогдох газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах;

3.3.13.нийслэлийн Дата төвд байрлах цахим мэдээллийн санг ашиглах тухай байгууллага хоорондын гэрээг үндэслэн мэдээлэл солилцох системтэй холбож, техникийн нөхцөлийг бүрдүүлэн ажиллах;

3.3.14.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын интернэт болон харилцаа холбооны зардлыг хэмнэх шинэлэг техник технологи, шийдэл нэвтрүүлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах, интернэт үйлчилгээ үзүүлэгч компаниудыг сонгон шалгаруулах, байгууллагуудад хэрэглэж байгаа интернэтийн үйлчилгээг сайжруулах, санал санаачилга дэвшүүлэх;

3.3.15.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудад хэрэгжүүлэх мэдээллийн технологийн төслүүдийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, хоорондын уялдаа холбоог хангах өгөгдлийн сан, системийн бичигдэх хэл, кодчиллын стандартыг мөрдүүлж, хяналт тавих.

3.4.Газар нь мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлээр дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1.цахим мэдээллийн сангийн төрийн нууцад хамаарах цахим бүртгэл, мэдээллийг ашиглах, хадгалахтай холбогдсон үйл ажиллагааны үе шат бүрт мэдээллийн нууцлалыг хангах, халдлагаас хамгаалах техник, программ хангамжийн арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэх;

3.4.2.нийслэлийн дата төвтэй холбогдсон байгууллагуудын хоорондын мэдээллийн солилцоог нэгдсэн зохицуулалтаар хангаж, цахим халдлага, мэдээлэл алдагдахаас хамгаалах;

3.4.3.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын цахим мэдээллийн сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цахим бүртгэл, мэдээллийн санг “Үндэсний дата төв” УТҮГ-ын дэд бүтэцтэй холбон байршуулах, төрийн байгууллагын цахим мэдээллийн санг “Үндэсний дата төв” УТҮГ-т шилжүүлэн байршуулах тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах;

3.4.4.нэгдсэн сүлжээ болон нийслэлийн Дата төвийн сүлжээний архитектурыг сонгох, нэгдсэн сүлжээнд гадаад болон дотоод сүлжээг суурилуулах, сүлжээний нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангах, хяналт тавих;

3.4.5.байгууллагын мэдээллийн сангийн дизайныг боловсруулж, өргөтгөлийг тухай бүр хийж баримтжуулах, мэдээллийн системийн үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангах;

3.4.6.нэгдсэн сүлжээ, мэдээллийн сан, сервер систем, сүлжээний хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зардлыг жил бүр нийслэлийн төсвийн төсөлд тусгаж, зохих журмын шийдвэрлүүлэх;

3.4.7.онцгой нөхцөл үүссэн үед мэдээллийн системийг нөхөн сэргээх, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.4.8.нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дүрэм, журмуудыг мөрдөж ажиллахад хяналт тавих, зөрчлийг арилгуулах;

3.4.9.нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, зөвлөмж өгөх, тусгай хэрэглээний мэдээлэл, төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээллийг нэгдсэн сүлжээгээр дамжуулах боломжийг бүрдүүлэх чиглэлээр Кибер аюулгүй байдлын газар болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.

3.5.Газар нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгнө.

3.6.Газар нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

Дөрөв. Хариуцлага

4.1.Энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Бусад зүйл

5.1.Энэ дүрмийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

5.2.Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.